

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас 2019 оны 1 дүгээр сарын дугаар

Тэргүүн Мэдээ.

ТХА-ны PROCESS төсөл өндөрлөв.



ТХА-ны “Суралцахуйг дэмжих мэргэжлийн байгуулагуудын чадавхийг бэхжүүлэх төсөл”(PROCESS)-ийн үйл ажиллагаа 1 дүгээр сарын 17-ны өдөр өндөрлөв. PROCESS төсөл нь “ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал”-ыг боловсруулж (хөтөлбөр, сурах бичиг, хичээл ба сурах чадварын үнэлгээг сайжруулах), боловсролын байгууллагын чадавхийг бэхжүүлэх зорилгоор 4 жилийн хугацаанд хэрэгжсэн юм. Төслийн үр дүнгийн нэг болох сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах гарын авлагыг нийт 1711 хүнд сургалт явуулах явцдаа боловсруулсан бөгөөд БСШУСЯ уг гарын авлагыг батласан талаарх мэдээг улсын хэмжээнд өргөн хүрээнд сурталчилсан байна. Монголчуудтай нягт хамтран ажиллаж, идэвхи зүтгэл гаргасан Фүкүо Томохиро мэргэжилтэнд талархал илэрхийлье.

Төслийн хэрэгжилт

“Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл” хэрэгжиж эхлэв.



Хөгжлийн төлөвлөгөө боловсруулах судалгааны хэлбэрийн техникийн хамтын ажиллагаа болох “Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл”-нь 1 сарын 10-ны өдөр эхний судалгааны баг томилогдон ирснээр хэрэгжиж эхлэв. Энэхүү төслийн хүрээнд Монгол Улсын тогтвортой хөгжилд чиглэсэн бүсчилсэн хөгжлийн дүр зураг, хөгжилд хүрэх арга замыг тусгасан үндэсний хэмжээний хөгжлийн цогц төлөвлөгөөг боловсруулахын зэргэцээ Монгол талын холбогдох байгууллагуудын (БХБЯ, ҮХГ зэрэг) чадавхийг бэхжүүлэхийг зорьж байгаа юм. Засгийн газар төдийгүй ААН-үүд, төрийн бус байгууллагууд, иргэдийн өргөн оролцоотойгоор Монгол Улсын дунд ба урт хугацааны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлон харуулахаар төлөвлөж байна.

Амьсгалын замын өвчний оношилгооны чадавхийг сайжруулах зориулалттай тоног төхөөрөмж олгов.



1 дүгээр сарын 10-ны өдөр Өвчний үндэс ТХА-ны “Уушги тоосжих болон Асбестийн шалтгаант уушги амьсгалын замын өвчлөлийг эрт илрүүлэх оношилгооны чадавхийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд сорьцын скайнер, зайн оношилгооны тоног төхөөрөмжийг Эмгэг судлалын үндэсний төвд гардуулан өгөх ёслол боллоо. Энэхүү төсөл нь 2018 оны 6 сараас эхлэн хэрэгжиж, дүрс оношилгооны эмч, эмгэг судлаач нарын чадавхийг дээшлүүлэхэд анхаарч ирсэн. Төслийн Япон талын хэрэгжүүлэгч байгууллага нь Institute of Support Center of Remote Medicine. Телемедицины дэмжлэг үзүүлэх төв юм. Монгол Улсад хөдөлмөрийн орчин, асбестийн хэрэглээ зэргээс шалтгаалсан амьсгалын замын өвчнийг эрт илрүүлэх, зөв оношилох арга хэмжээ учир дутагдалтай байгаа тул уг ёслолд оролцсон Эрүүл мэндийн дэд сайд Бямбасүрэн нарын албаны хүмүүс энэхүү төхөөрөмжийг ашигласнаар нөхцөл байдал сайжирна гэдэгт итгэж байгаагаа илэрхийлж байлаа.


Өвсний үндэс ТХА-ын хүрээнд дэмжлэг үзүүлж буй шууд борлуулалтын цэг өвөл ажиллаж эхэллээ.



Төв аймгийн Борнуур суманд байрлах шууд борлуулалтын цэг 1 дүгээр сарын 11-ний өдрөөс ажиллаж эхэллээ. Өвсний үндэс ТХА-ын “Хөдөө аж ахуйн бүтээгдхүүний эргэлтийг сайжруулах, хөрс сайжруулах технологи нэвтрүүлэх замаар тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд баригдсан шууд борлуулалтын цэгийг 2017 онд нээсэн боловч өвлийн улиралд борлуулах газар тариалангийн бүтээгдэхүүний төрөл ховор байснаас зөвхөн зуны улиралд үйл ажиллагаа явуулж байсан. Төслийн Япон талын хэрэгжүүлэгч байгууллага болох Хоккайдо мужийн Жижиг дунд бизнес эрхлэгчдийн холбооны Токачигийн салбар нь 2018 оны 12 дугаар сард орон нутгийн иргэдэд семинар зохион байгуулж, газар тариалангийн бүтээгдэхүүнээс гадна орон нутагт үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг борлуулах санал тавьснаар орон нутгийн 17 иргэний оролцоотойгоор тус төв нь өвлийн улиралд үйл ажиллагаа явуулахаар болж байна.

[Шууд борлуулалтын цэг FB](#) | [Шууд борлуулалтын цэг FB](#)

Токио хотын үйлдвэрийн хаягдал усны талаарх арга хэмжээний туршлагыг монгол талтай хуваалцав.



Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид арьс ширний үйлдвэрүүдийн хаягдал ус их хэмжээгээр урсан ирдэгээс цэвэршүүлэлтийн чанар доголдохын зэргэцээ цэвэрлэх байгууламжийн насжилт буурах зэрэг асуудал тулгарч байна. ЖАЙКА-нь эдгээр асуудлыг шийдвэрлэх, нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн цаашдын хамтын ажиллагааны боломжийг судалж үзэх зорилгоор Улаанбаатар хотод үйлдвэрийн хаягдал усны талаар авч буй арга хэмжээний талаарх мэдээлэл цуглуулах судалгааг хийж байна. Дээрх судалгааны хүрээнд 1 дүгээр сарын 31-ний өдөр Токио хотын Бохирын шугам сүлжээний газрын мэргэжилтэн илтгэл тавьж, Токио хотод авч хэрэгжүүлдэг арга хэмжээг таницуулах семинарыг зохион байгуулав. Семинарт оролцогчид үйлдвэрийн бохир усны талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар идэвхтэй санал солилцсон бөгөөд, хамтрагч байгууллагуудын оролцоог хангасан ач холбогдолтой семинар боллоо гэж үзэв.

Бусад төсөл.

- 1 сарын 16: Төлөвлөлтийн судлаач Вакай Икуко, эрүүл мэндийн ажилтан Онокита Юко нар (ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар) томилогдон ирэв.
- 1 сарын 31: Төлөвлөлтийн судлаач Такамура Асами, эрүүл мэндийн ажилтан Когурэ Масуми нар (ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар) нутаг буцав.

Сайн дурын үйл ажиллагаа

Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга

(Ганцаарчилсан сургалт явуулж, бүлгээр нь халамжлан хүмүүжүүлж байна.)



Сужаташанд ТББ-д харьяалагдан үйл ажиллагаагаа явуулж буй сайн дурын гишүүн Савада Миса (2017 оны 2-р ээлж, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд үзүүлэх дэмжлэг) Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн цэцэрлэгүүдэд ажиллаж, ой ухааны болон хэл ярианы хоцрогдолтой хүүхдүүдэд ганцаарчилсан болон групп сургалтыг зохион явуулж байна. 1 дүгээр сарын 14-ний өдөр жил гаруй хугацаанд явуулж ирсэн үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор холбогдох талуудын хурлыг зохион байгуулсан бөгөөд тус хурал дээр тодорхой хүүхдийн жишээн дээр өөрийгөө илэрхийлэх, бусад хүүхдүүдтэй харьцах чадварын хувьд бодит үр дүн гарч байгааг цэцэрлэгийн багш нарын зүгээс сайшаан дурдаж байсан юм. Сайн дурын гишүүн маань томилогдон ажиллах үлдсэн хугацаандаа улам их амжилт гаргахын төлөө хамтран ажиллах эрмэлзэл дүүрэн байгаагаа илэрхийллээ.

Бусад сайн дурын үйл ажиллагаа

- 1 сарын 23: 2018 оны 3-р ээлжийн 9 сайн дурын гишүүн ирэв: Ямазаки Юухоо (физик эмчилгээ /Дорноговь аймгийн эрүүл мэндийн газар), Уэхара Аюми (хөгжим/Багануур дүүрэг, 125-р сургууль), Кодэра Юүби (Япон хэлний багш/Эрдмийн ундраа цогцолбор), Сато Эрико (бага ангийн багш/Дорноговь аймгийн 2-р сургууль), Сузуки Мэгуми (хоолны боловсрол/Орхон аймгийн 4-р сургууль), Хаттори Тамаки(хүүхэд задучуудын үйл ажиллагаа /Дархан Уул аймаг, МСҮТ),Фунакоши Юүки(япон хэлний багш/Дорноговь аймгийн 5-р сургууль),Мацумото Саори (сувилагч/Дорнод аймгийн Зүүн бүсийн оношлогоо,эмчилгээний төв), Ямагучи Чика (япон хэлний багш/ УБ хотын 18-р сургууль)



ЖАЙКА-ийн Сургалт Төгсөгчдийн Холбоо

Сургалт төгсөгчид “Үйлдвэрлэлд 5S-ийг хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалт зохион байгууллаа.



1 дүгээр сарын 4-ний өдөр 2015 онд “5S-д суурилсан Япон маягийн менежмент” сургалтанд хамрагдсан төгсөгчид Star Window компани дээр “Үйлдвэрлэлд 5S-ийг хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалт зохион байгууллаа. 5S-ийн талаарх мэдлэг болон чадавхийг дээшлүүлэх зорилготой уг сургалтанд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нийт 80 хүн хамрагдлаа. Сургалтын үеэр 5S-ийн тухай ойлголт, хэрэгжүүлэх арга замууд, үр ашиг, үйлдвэрийн 7 мұда, Японы бодит жишээ зэргийг танилцуулсан бөгөөд оролцогчдын сэтгэгдэл маш өндөр байлаа.



Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага(ЖАЙКА) Монгол дахь Төлөөлөгчийн Газар.

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс

(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)

Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 Имэйл: mg_oso_rep@jica.go.jp